



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/14

Сант сум

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл
ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурлан үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг тооцон иргэдэд танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай зохион байгуулж, идэвх санаачилгатай ажиллахыг сумын төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (А.Одхүү)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: *МОН*
Хянасан: *Ч. Амарман*
Хувь: *2.*
2022 02 28.